



Хэвлэлийн мэдээ
2016 оны 6-р сарын 15-ны өдөр, Лхагва гараг

Холбогдох утас:
9710-9009

**Монгол дахь Америкийн Худалдааны Танхим
Монгол дахь Олон Улсын Санхүүгийн Байгууллагуудын Удирдлагуудтай
Уулзалт Зохион Байгууллаа**

2016 оны 6-р сарын 14-нд Монгол дахь Америкийн Худалдааны танхим (АмЧам) нь Монгол дахь Олон Улсын Санхүүгийн Байгууллагуудын удирдлагууд болох Дэлхийн Банкны Монгол дахь Суурин Төлөөлөгч ноён Жэймс Андерсон, Европын Сэргээн Босголт, Хөгжлийн Банкны Монгол дахь Суурин Төлөөлөгч ноён Мэттью Лэ Блан болон Азийн Хөгжлийн Банкны Монгол дахь Суурин Төлөөлөгчийн Газрын захирал ноён Роберт Шоэлхаммэр нартай уулзалт зохион байгууллаа.

Уулзалтанд АмЧамын гишүүд болон бизнесийн бусад төлөөлөл болох 60 гаруй бизнес эрхлэгчид оролцож УИХ-ын ээлжит сонгуулийн дараахь Монгол улсын эдийн засгийн төлөв байдал, сорилт болон боломжуудын талаар дэлгэрэнгүй хэлэлцүүлэг өрнүүлсэн юм.

Дэлхийн Банкны Монгол дахь Суурин Төлөөлөгч ноён Жэймс Андерсон уулзалтын үеэр Монгол улсын ДНБ-ний өсөлтийн талаар хэлсэн үгэндээ “Оюу Толгойн бүтээн байгуулалтын хоёрдахь үе шат дуусч, эдийн засагт хувь нэмрээ оруулж ирэх үед, нийт эдийн засагт эерэгээр нөлөөлөх болно” гэв

Европын Сэргээн Босголт, Хөгжлийн Банкны Монгол дахь Суурин Төлөөлөгч ноён Мэттью Лэ Блан гадаадын шууд хөрөнгө оруулалтын талаар хэлэхдээ “Гадаадын хөрөнгө оруулалтыг илүү ихээр татахын тулд бидэнд чанартай тоног төхөөрөмж болон ноу-хаугаа мэддэг мэргэжилтэн хэрэгтэй” гэв.

“Сонгуулийн дараа Монгол улсын засгийн газар өрөө төлж эхлэхийн тулд зарлагаа огцом багасгах хэрэгтэй” хэмээн Азийн Хөгжлийн Банкны Монгол дахь Суурин Төлөөлөгчийн Газрын Захирал ноён Роберт Шоэлхаммэр хэмээн тус тус онцолсон юм.

АмЧам Монголын ТУЗ-ийн дарга ноён Жэймс Лиотта уулзалтыг дүгнэн хэлсэн үгэндээ “Хувийн хэвшлүүд болон олон улсын санхүүгийн байгууллагууд нягт хамтран ажиллах нь чухал. Бидэнд нийтлэг сонирхол, тулгамдсан асуудал олон бий” гэсэн юм.

АмЧам Монголын тухай

АмЧам Монгол нь АНУ-Монгол Улс хоорондын бизнесийн түншлэлийг өргөжүүлэх, бэхжүүлэх, эрх ашгийг нь хамгаалах болон Америкийн хөрөнгө оруулалтыг Монголд татах чиглэлээр ажилладаг бие даасан, гишүүддээ үйлчлэх төрийн бус байгууллага юм. АмЧам Монгол нь 3 сая гаруй гишүүдтэй дэлхийн хамгийн том бизнесийн холбоонд тооцогддог Америкийн Худалдааны Танхимын албан ёсны салбар юм. Мөн АмЧам Монгол нь Ази Номхон далайн 29 орнуудын Америкийн худалдааны танхимуудыг нэгтгэдэг Ази Номхон далайн орнуудын Америкийн Худалдааны Танхимуудын Зөвлөл байгууллагын гишүүн юм.